

# “ЭРДЭНЭТ СУВРАГА” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛТИЙН ТОГТООЛ

2024 оны 01-р сарын 19-ны өдөр

№ 01.

Улаанбаатар хот

“Эрдэнэт суврага” ХК нь ногдол ашиг хувиарлах тухай ТОГТООХ нь.

**Нэг.** “Эрдэнэт суврага” ХК нь 2023 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 5 / таван / төгрөгийн ногдол ашиг хувиарлахаар тогтоосугай.

**Хоёр.** Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.

**Гурав.** Ногдол ашгийн мөнгийг “ҮЦТХТ” ТӨХХК-иар дамжуулан 2024 оны 6-р сарын 30-ны өдрийн дотор хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаар шийдвэрлэсүгэй.

ТУЗ-ЫН ДАРГА



О.МАРАЛМАА

# “ЭРДЭНЭТ СУВРАГА” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 02-р сарын 24-ны өдөр

Дугаар .03 .

Улаанбаатар хот

“Эрдэнэт Суврага” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн  
ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын “Компанийн тухай хууль” болон СЗХорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Эрдэнэт Суврага” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны ээлжит хурлыг 2024 оны 04-р сарын 09-ны өдрийн 11.00 цагт Булган аймаг, Булган сум, 1 баг, Зам ангийн байранд хуралдуулсугай.
2. “Эрдэнэт Суврага” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар доор дурьдсан асуудлыг хэлэлцэхээр тогтоосугай. Үүнд:
  - Компанийн санхүүгийн тайлан түүнд хийгдсэн хараат бус Аудитын дүгнэлт
  - Ноогдол ашиг хувиарлах тухай ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн, батлах
  - Компанийн 2023 оны бизнес үйл ажиллагааны тайлан
  - Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөг батлах
  - ТУЗ болон ТУЗ –ийн гишүүдийг сонгох
  - ТУЗ болон ТУЗ –ийн гишүүдийн урамшууллын дүнг тогтоох
  - Компанийн хувьцааг хуваах тухай төсөл
  - Бусад
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 03-р сарын 13-ны өдрөөр тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар Л.Гантуяаг, тооллогын комиссын даргаар Б.Батчимэгийг тус тус томилсугай.
5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг хүргэхээр 2024 оны 02-р сарын 27-ны дотор өдөр тутмын 2-с доошгүй сонин болон хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр мэдээлэх. Энэ мэдээллийг дээрх хэлбэр шаардлагын дагуу анх мэдээллэсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа дахин мэдээллэхийг хурал зохион байгуулах коммист /Л.Гантуяа/-д даалгасугай.
6. Ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хурлын дэгийг 01-р хавсралтаар, хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь 02-р хавсралтанд заасан бичиг баримттай

[gantuya3579@gmail.com](mailto:gantuya3579@gmail.com) хаягаар буюу ажлын өдрүүдэд “Аргай бэст ҮЦК” ХХК-ийн 11-327026, 8803-4778 утсаар холбогдон танилцах эрхтэй болохыг дурьдсугай.

7. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс энэхүү хурлаар хэлэлцэх асуудлаар санал авах саналын хуудсын агуулгыг 03-р хавсралтаар баталсугай.
8. Хувьцаа эзэмшигчээс “Санал авах хуудас”-ыг хүлээн авах сүүлийн өдрийг харьяалагдах үнэт цаасны компаниар нь дамжуулан хурал хуралдах өдрөөс ажлын 5-с доошгүй хоногийн өмнө байхаар тогтоосугай.
9. Хурал хуралдуулах тухай шийдвэрийг гаргаснаас хойш 3 хоногийн дотор “Эрдэнэт Суврага” ХК-ийн “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг холбогдох маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргүүлэхийг хурал зохион байгуулах комисст /Л.Гантуяа/-д даалгахаар тогтоосугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар компанийн хувьцааг хуваах төслийг хэлэлцэн шийдвэрлэсүгэй.

ТУЗ-ЫН ДАРГА



О.МАРАЛМАА